



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/30

Мандалговь

### Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрийг олон нийтэд сурталчлан өнгөрүүлэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр”-ийг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 96500 (Ерэн зургаан мянга таван зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.

Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА

Ц. ГАНЗОРИГ



431190055